



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/316

Чингис хот

Аюулт үзэгдлийн хор уршгийг арилгах, сэргээн  
босгоход хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хүчтэй шороон шуурганы улмаас Хэрлэн сумын 4 дүгээр багийн "Хэрлэн" орон сууцны хорооллын А-55 дугаар байрны гадна дулаалгын хөөсөнцөр хэсэгчлэн унасан хохирлыг сэргээн босгох зорилгоор хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 9,635,919 (есөн сая зургаан зуун гучин таван мянга есөн зуун арван ес) төгрөгийг гамшгийн эрсдэлийн сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нэмдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011689